

ПЛИТОНИТ СУПЕРКАМИН ХАЛУУНӨРЛӨГ

Үсгийн утга:

ХалуунӨрлөг

Нэршил:

Байшин дотор болон гадна шавар тоосгоор зуух, камин зуух, яндан, шорлогны зуухны гадна ханыг өрөх халуунд тэсвэртэй зуурмаг

Тэмдэглэгээ:




ОРОСЫН ЗУУХНЫ

ХОЛБОО

Давуу тал:

- ☐ Гадна болон дотор талын ажилд зориулсан
- ☐ Бага зарцуулалттай
- ☐ Тоосго урьдчилан чийглэх шаардлагагүй
- ☐ Урт эдэлгээтэй - зуурмагийн тэлэлтийн коэффициент нь тоосгоны тэлэлтийн коэффициенттой тохирно
- ☐ Халуунд тэсвэртэй марк Т10

Өнгө



СААРАЛ

ТООСГОН-УЛААН

Байшин дотор болон гадна шавар тоосгоор зуух, камин зуух, яндан, шорлогны зуухны гадна ханыг өрөх халуунд тэсвэртэй зуурмаг. Технологийн өндөр үр ашигтай, ус барин тогтоох чадвартайгаас гадна чийгт тэсвэртэй, хагаралд тэсвэртэй, материалын зарцуулалт багатай. Зуурмагийн температурын тэлэлтийн коэффициент нь шавар тоосгоныхтой ойролцоо байна. Өрлөгийн залгаасны санал болгож буй зузаан нь 4-6 мм байна. Өрлөгийн залгаасны хамгийн их зузаан нь 15 мм байна. Дүүргэгчийн хамгийн том ширхгийн хэмжээ — 2,5 мм. Савлагаа — 20 кг

Бүтээгдэхүүний зарцуулалт

Бэлэн зуурмагийн хэмжээ: 12,5-13,5 литр/20 кг хуурай хольц байна. Залгаасны зузаан дахь материалын зарцуулалт 5 мм-ийн зузаантай залгаасны материалын хэрэглээ нь 0.4 кг/тоосго (хэмжээ 250x120x65), өөрөөр хэлбэл 20 кг хуурай хольц нь 50 орчим тоосгоны өрлөгийг хийхэд зориулагдсан.

Ажлын нөхцөл

Ажлын явц болон гүйцэтгэлээс хойших 7 хоногт агаарын температур болон тоосгыг +5°C хэмээс +30°C хэмийн хооронд байх нь зохимжтой. Ажлын явцад зуурмагийн хольцын температур, +10 °C хэмээс +30°C хэм хүртэл байх нь зохимжтой.

Суурийг бэлтгэх

Тоосгоны гадаргуу нь хуурай байх ёстой. Хольцын өндөр ус тогтоогч чадвартайгаас тоосгыг норгох шаардлагагүй. Ажлыг шороо, тоос, тос, өөх тос, бүх төрлийн будаг, шавар, цементийн зуурмагаас цэвэрлэсэн хуурай гадаргуу дээр хийнэ. Тоосго нь сайн шатаагдсан, хагарал, хөндий, чулуу болон бусад гаднын материалгүй байх ёстой; зөв хэлбэртэй байх ба товших үед тод, цэвэр дуу гаргах.

Шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний арга боловсруулалтын хэлтсийн эрхлэгч _____ Туршилт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга _____ 27.01.2021 4 хуудасны 1 дүгээр

Зуурмаг бэлтгэх

Зуурмагийг бэлтгэхийн тулд энгийн ундны усыг ашиглана. Холих харьцаа: 1 кг хуурай өрлөгийн хольцод 0,18-0,22 литр (20 кг-д 3,6 - 4,4 литр) ус шаардагдана. Хуурай хольцыг тасалгааны температурт урьдчилан хэмжин авсан ус уруу хийнэ, нэгэн төрлийн жигд болтол нь 2-3 минутын турш эргэлтийн хурд нь 600 эргэлт/мин-ээс ихгүй байх цахилгаан холигч эсвэл цахилгаан өрмийн тусламжтайгаар холино. Зуурмагийг ойролцоогоор 10 минут амраан дахин холино. Энэ үед зөвшөөрөгдсөн хамгийн дээд хэмжээний үлдсэн усыг нэмж хэрэглэж болно. Бэлэн болсон зуурмагийн хольцыг хэрэглэх хугацаа 4 цагаас илүүгүй байна.

Ажлын дараалал

Цул, удаан эдэлгээтэй хананы бүтцийг бий болгохын тулд өрлөгийг хажуугийн эгнээний босоо залгаасыг хаан тоосгыг хагас буюу дөрөвний нэгээр нь шилжүүлэх замаар гүйцэтгэнэ. Мөр бүрийг тавихын өмнө тосгонуудыг зуурмаггүйгээр ("хуурай") өрж тавих шаардлагатай. Тоосгоны хавтгайтай тэнцэхүйц талбайд өрлөгийн зуурмагийг тавьж, тэгшилнэ. Тоосгыг нь түрхсэн зуурмаг дээр тавьж, гараараа дарах эсвэл хусуурын бариулаар тогших замаар тэгшилнэ. Дараагийн мөр бүрд тоосго дараалан тавихдаа түүний төгсгөлийн хэсэгт зуурмагийг түрхэн хэрэглэнэ. Материалын зарцуулалтыг бууруулж, тоосгоны бүх талбайд зуурмагийн хольцыг жигд тараахын тулд ховилтой хусуур ашиглахыг зөвлөж байна. Өрлөгийн явцад хананы дотоод болон гадаад гадаргууг залгааснаас шахагдаж гарсан зуурмагаас гөлгөр гадаргуу үүсгэх хүртэл цэвэрлэж, дотоод гадаргууг арчиж нойтон сойз эсвэл нойтон даавуугаар арчина. Тоосго тавихдаа зайлшгүй залгаасыг холбох дүрмийг баримталж эгнээ тус бүрийн хэвтээ байдал, өрлөгийн тэгш байдлыг (гүдгэр, хонхойгоогүй) бүх талаас нь шалгах шаардлагатай. Өрлөгийн хэвтээ ба босоо залгалтыг зуурмагаар бүрэн дүүргэх ёстой. Шавар тоосгоор хийсэн гадна хана галд тэсвэртэй тоосгоор хийсэн галын өрдөх хэсгийн хоорондох зайг хадгалах шаардлагатай.

Зуухны хатаалга

Хэрэглэхийн өмнө байгууламжийг өөрөөр нь (байгалийн) болон хиймэл аргаар хатаана. Байгалийн аргаар хатаах үед байгууламж байрладаг өрөөний цонх, хаалгыг нэвт салхи байхгүйгээр бүтэн өдрөөр нээлттэй байлгах хэрэгтэй. Бүх хаалт, агааржуулагч, галын хайрцаг, үнсний савны хавхаг нээлттэй байх ёстой. Энэ төрлийн хатаалгад 7-10 өдөр шаардагдана. Хиймлээр хатаах үед бүтэц нь хуурай түлшээр үе үе халааж, түүний хэмжээг аажмаар нэмэгдүүлдэг. Анхны удаа галлахын өмнө яндангаа цаас, сүрэл эсвэл модны үртэс шатааж дулаацуулах шаардлагатай. Эхний ээлжид зуухыг өдөрт хоёр удаа 60-90 минутаас илүүгүй хугацаанд бага хэмжээний түлшээр халааж, үнс, галын хайрцгийн хаалга, хаагч, агааржуулагч хавхлагыг онгойлгоно. Цаашид түлшний хэмжээг өдөр бүр нэмэгдүүлж, гэхдээ зуухны гаднах гадаргуугийн температур +50°C хэмээс нэмэгдэхгүй байх ёстой. Зуухны гадаргуу дээр чийгтэй толбо харагдахаа больж, агааржуулагч эсвэл хаагч хавхлага дээр конденсацийн ул мөр харагдахаа больсон тохиолдолд хатсан гэж үзнэ.

Зуухны ашиглалт

Зуух, камин зуухыг ажиллуулах явцад гаднах өрлөгийн гаднах гадаргуу хэт халах нь өрлөгийн тоосго, өнгөлгөөний материалд хагарал үүсэх, хүрэх үед түлэгдэх шалтгаан болдог. Гаднах өрлөгийн гаднах гадаргууг 250°C хэмээс дээш температурт халаахад өрлөгийн залгаасны өнгө өөрчлөгдөж эхлэх бөгөөд энэ нь зуухны буруу ашиглалт, хэт халалтыг илтгэнэ.

Анхааруулга

Ажил гүйцэтгэхдээ барилгын норм ба дүрэм 41-01-2003 шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай. Зуурмаг болон металл бүтээгдэхүүн хоёрын хооронд хүрэлцэхээс зайлсхий. Температурын өргөтгөх холбоос нь 5 мм-ээс багагүй байх ёстой. Зуух, камин зуух, яндан нь байшингийн барилгын бүтэцтэй хөдөлгөөнгүй бат холбогдож болохгүй. Хөлдөөх аргыг ашиглан зуух тавих ажлыг гүйцэтгэх, түүнчлэн хүйтэн тоосго, зуурмаг ашиглахыг хориглоно. Дээр заагдсан шинж чанарууд нь орчны температур $(20+2\pm 60+10)^{\circ}\text{C}$, агаарын харьцангуй чийгшил $(60\pm 10)\%$ -д үйлчилнэ. Ажил гүйцэтгэхдээ нийтийн ажил хийх заавар, барилгын ажилд аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх арга хэмжээг дагаж мөрдөх ёстой. Хэрэв өрлөгийн үеийг дараа нь засах шаардлагатай бол ПЛИТОНИТ Супер-Камин ТермоРемонт ашиглана уу. Ажил гүйцэтгэх явцад зуурмагийг үе үе хольж байх ёстой. Бэлэн зуурмаг дээр нэмж ус хийхийг хориглоно. Ажил гүйцэтгэхдээ бээлий өмсөөрэй. Зуурмагийг арьс, нүдэнд хүрэхээс зайлсхийгээрэй. ХҮҮХДЭЭС ХОЛ БАЙЛГА!

Тээвэрлэлт болон хадгалах нөхцөл

Хуурай хольцыг ачаа тээвэрлэх дүрмийн дагуу бүрхүүлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Хуурай хольцтой уутыг савлагааны аюулгүй байдал, чийгээс хамгаалсан хаалттай хуурай өрөөнд хадгална. Үйлдвэрлэгчийн саванд хадгалах хугацаа нь тээвэрлэх, хадгалах нөхцөл зөрчигдөөгүй үед үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар байна.

Орц, найрлага

Усан зууралдуулагч, халуунд тэсвэртэй дүүргэгч, өөрчлөх нэмэлт

Үйлдвэрлэгчийн баталгаа

Хэрэглэгч тээвэрлэх, хадгалах нөхцөл, энэхүү гарын авлагад заасан зааврыг дагаж мөрдсөн тохиолдолд хольц нь техникийн үзүүлэлтүүдийн шаардлагад нийцэж байгааг үйлдвэрлэгч баталгаажуулна. Үйлдвэрлэгч нь материалтай ажиллах технологийг дагаж мөрдөхгүй байх, түүнчлэн эдгээр зааварт заагаагүй зорилго, нөхцөлд ашиглах үед хариуцлага хүлээхгүй. ГОСТ Р 8.579-2001 стандартын дагуу цэвэр жингийн хазайлт байна. Бүтээгдэхүүнийг бүх төрлийн иргэний барилгад ашиглахыг зөвшөөрсөн. (Аэфф<370 Бк/кг байх ОХУ-ын Цацрагийн аюулгүй байдлын стандартууд НРБ-99/2009, ариун цэврийн дүрэм, журам СанПиН 2.6.1.2523-09 нийцсэн).

Техник үзүүлэлтүүд

Дүүргэгчийн хамгийн том ширхгийн хэмжээ		2,5 мм
1 кг хольцод* хэрэглэх усны хэмжээ		0,18 - 0,22 л
20 кг хольцод		3,6 - 4,4 л
Бүтээгдэхүүний зарцуулалт	тоосгоор өрлөг хийх үед	5 мм зузаантай түрхэх үед 20 кг ~ 50 тоосго
Бэлэн болсон зуурмагийн хольцыг хэрэглэх хугацаа		4 цагаас багагүй
Өрлөгийн залгаасны зузаан		3-оос 15 мм хүртэл
Зуурмагийн шахалтын үеийн бат бэх		2,5 МПа-аас багагүй
Зуурмагийн үлдэгдэл тунгалаг чанар		1,5 МПа-аас багагүй
Зуурмагийн хүйтэнд тэсвэртэй байдлын марк		F35 багагүй
Ашиглалтын үеийн хамгийн их температур		+400°C

*Тодорхой багц бүтээгдэхүүний хувьд усны тохиромжтой хэрэглээг Үйлдвэрлэгчийн чанарын баримт бичигт заасан байдаг

Чухал зөвлөмжүүд

Шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний арга боловсруулалтын хэлтсийн эрхлэгч _____ Туршилт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга _____ 27.01.2021 4 хуудасны 3 дүгээр

Зуухыг өөрийн гараар хэрхэн яаж хийх талаарх зөвлөмжийг удахгүй манай www.Superkamin.ru шинэ вэб сайтаас олж аваарай. Зуух, пийшингийн төслүүдийг энд цуглуулж үзүүлсэн байгаа. Зуухны өрөх дарааллыг өрлөгийн эгнээ тус бүрээр үзүүлэв. Зуухны мастеруудын нарийвчилсан зааварчилга, мэргэжлийн зургийг ашиглан та өөрөө зуух барих боломжтой юм. PLITONIT СуперКамин цувралын бүтээгдэхүүний тусламжтайгаар та камин зуух, шорлогийн зуух, сауны зуух, Швед зуух, тогоонд зориулсан зуух болон бусад төрлийн зуух хийх боломжтой.

Хэрэв танд зууханд шавардлага эсвэл камин зууханд шавардлага хэрэгтэй бол PLITONIT СуперКамин Термо Шавардлагыг ашиглаарай. Зуух, камин зуухны өнгөлгөөний хувьд халуунд тэсвэртэй хавтангийн цавуу PLITONIT СуперКамин ТермоКлей ашиглана.